



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/150

Улаанбаатар хот

### Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь хэсэг, Монгол Улсын засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зориулалтаар Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/125 дугаар захирамжаар Налайх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт олгосон 3000м<sup>2</sup> хэмжээтэй 101,700,000 (Нэг зуун сая, долоон зуун мянга) төгрөгийн үнэ бүхий газрыг байгууллагын эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Энэхүү тушаалд заасан эргэлтийн бус хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэж авахыг Ахлах нягтлан бодогч (Д.Уянга), нярав (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500326